

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР



# ХОТ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ХЭЛТЭС

2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

## НЭГ: ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

“Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан нийслэлд хэрэгжих зорилтоос байгууллагын /нэгжийн / хамаарал бүхий заалтын биелэлт,

НЗДҮАХ-ийн 6.1.7 Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах ажлыг эрчимжүүлнэ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг өргөжүүлэх, төслийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар “Харилцан ярилцъя-Хамтдаа шийдье” өргөтгөсөн уулзалтад холбогдох материалыг бэлтгэн мэдээлэл өгч хамтарч ажилласан.

Мэргэжлийн зөвлөлийн хурлаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд танилцуулга бэлтгэн, хэлэлцүүлэн шийдвэрлэж архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан хүлээлгэн өгсөн. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороо, Оргил төсөл, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо Бүргэд констракшн ХХК, Батхэрэйд ХХК, Баянзүрх 8, 16 дугаар хороо Баганат өргөө ХХК, Гангар инвест ХХК-ын мэдээллийг E-Registration –д бүртгэж ажилласан.
- Баянзүрх дүүргийн 8, 16-р хороо, Батлан хамгаалах сургууль орчим “А”, “Б” хэсэгчилсэн талбай” 93.8 га газарт “Баганат Өргөө” ХХК, “Гангар Инвест” ХХК
- Баянзүрх дүүргийн 12-р хороо, Чулуун овоо орчим “В хэсэгчилсэн талбай” 25.6 га газарт “Батхэрэйд” ХХК
- Баянгол дүүргийн 11-р хороо, Бичил-7 орон сууцны хороолол орчим “Б хэсэгчилсэн талбай” 1.5 га газарт “Очирням проперти” ХХК
- Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутагт дахин төлөвлөлтийг эхлүүлээд орхисон “Их Өргөө” ХХК-ийн үйл ажиллагаанаас болж хохирсон 85 иргэний асуудлыг 2021 оны 01 сарын 08 өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж, Мамбадацан хийд орчмын “В” хэсэгчилсэн талбайд газар чөлөөлсөн үл хөдлөх хөрөнгө өмчлөгч 85 өрхийг түр орон сууцаар хангах, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг “Нийслэлийн Орон сууцны корпорац” ХК-д шилжүүлэх шийдвэр гаргуулан ажилласан.
- Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх эрх цуцлагдсан /Жи Ди ХХК, Назу проперти ХХК/ Сонгинохайрхан дүүргийн 5, 6, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Ханын материал орчим, Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт Арьс ширний ажилчдын байр орчимд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ерөнхий төлөвлөгөөний танилцуулгыг боловсруулж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/68 дугаар захирамжаар Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны удирдамж шинэчлэн батлагдсантай холбоотой холбогдох материалыг Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газарт хүлээлгэн өгсөн.
- Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо “Идэр Тулга” СӨХ-с гаргасан гомдлын дагуу иргэн Б.Билгүүний барилгатай холбоотой мэдээлэл бэлтгэж 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдөр “Идэр Тулга” СӨХ-ны төлөөлөл, холбогдох албаны хүмүүсийг байлцуулан албан уулзалт зохион байгуулсан.
- БЗД, 13, 14-р хороо, Орон сууцны 14-р хороолол орчим “Д хэсэгчилсэн талбай” 11.3 га газарт “Шинэ Гэр Түншлэл” ХХК-ийн барилгажилтын төслийг хянан батлуулсан.

НЗДҮАХ-ийн 6.1.9 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна.

- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг зарлах ажлыг зохион байгуулж, 42 багцын 89 барилгын сонгон шалгаруулалтын баримт бичгийг дахин боловсруулж хянан батлуулсан.
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын А/1255 дугаар захирамжаар ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төслийг эрчимжүүлэх, асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалтын асуудал хариуцсан Төслүүдийн удирдагч Б.Сүхбаатар даргаар ахлуулан нийт 6 удаа зохион байгуулж хурлаас өгсөн үүрэг даалгавын дагуу Нийслэлийн 9 дүүргээс сонгогдсон Монгол Улсын Их Хурлын гишүүд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт төсөл хэрэгжүүлэх санал ирээгүй, улсын төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгаа нийтийн зориулалттай орон сууцны барилгын сууц өмчлөгчдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлэн ажилласан.
- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилгыг 2021.02.24-2021.03.24, 2021.05.17-2021.06.14, 2021.09.13-2021.10.12, 2021.11.15-2021.12.15-ны өдрүүдэд <https://uda.ub.gov.mn/>, <http://ulaanbaatar.mn/> цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.
- Ашиглалтын төлөв байдал нь өнөөгийн мөрдөж буй “Газар хөдлөлтийн бүсэд барилга төлөвлөх норм ба дүрэм” БНБД 22.01.01\*2006”, “Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм” БНБД 22-04-16-ийн шаардлагыг хангахгүй, болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй, хийц, бүтээц нь ослын байдалтай сургууль, дотуур байр, цэцэрлэгийн зориулалттай 47 барилгын жагсаалтыг гаргаж ажилласан.
- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны “Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор батлагдсан нийт 58 барилгыг шинээр барих төслийг холбогдох хуульд заасан эх үүсвэрээс санхүүжүүлэн эхлүүлэх шаардлагатай тухай танилцуулга материалыг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу сайжруулж ажилласан.
- Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нийтийн зориулалттай орон сууцны 27 дугаар байр, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны 53 дугаар байр, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны 51, 52 дугаар байрны төсөл хэрэгжүүлэгчээр шалгарч Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/639, А/984, 2020 оны А/1267, А/1268 дугаар захирамжаар “Элит констракшн” ХХК, “Эм Ти Эм Сити инженеринг” ХХК “Бүтээлч трэйд” ХХК, “Улаанбаатар пропертиз” ХХК-аар батламжлагдсан төсөл хэрэгжүүлэх графикчилсан төлөвлөгөөг батлуулах товч тайлбар боловсруулж батлуулан аж ахуй нэгжид хүргүүлсэн.
- 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай Хөдөө аж ахуйн хангамжийн ажилчдын 27-р байрны асуудлаар Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт тухайн байрны эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч “Ансестор” ХХК-ны төлөөлөлтэй гурван талт албан уулзалт зохион байгуулсан. Уулзалтаас төсөл хэрэгжүүлэгч өөрийн хүсэлтээр тухайн төслийг хэрэгжүүлэхээс татгалзсан.



- Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны Арьс ширний 31 дүгээр байрны 18 оршин суугчийн төлөөлөл 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр М210208008 дугаартай цахим өргөдлөөр төсөл хэрэгжүүлэгчээс татгалзсан, төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлуулах хүсэлт ирүүлсний дагуу Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2-т заасан хэлбэрээр төсөл хэрэгжүүлэгч “Бүтээлч трэйд” ХХК-д сонсох ажиллагааг зохион байгуулж нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1267 дугаар захирамжаар “Бүтээлч трэйд” ХХК-д олгосон төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах Нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан.
- Барилга, хот байгуулалтын яамны дэд сайдад ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны барилгуудын ирэх 4 жилд хэрэгжүүлэх боломжтой байршлууд, өрхийн тоо, төлөвлөлтийн талаарх мэдээллийг тодорхой маягтын дагуу хүснэгтээр мэдээг хүргүүлсэн.
- 2021 онд журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдсаны үр дүнд одоогийн байдлаар 211 айлын 11 орон сууцыг буулган 266 айлын 2 орон сууц ашиглалтад оруулсан байна.

#### **2021 онд 211 айлын 11 барилга буулгасан**

- Баянгол дүүргийн 04 дүгээр хороо, Давхар - 1, 2, 3, 4, 5 дугаар байр
- Баянгол дүүргийн 3 дугаар хороо, 22, 37 дугаар байр
- Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байруудыг тус тус буулгаж барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

#### **2021 онд 266 айлын 2 барилга ашиглалтад орсон**

- Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд 126 айлын 1 орон сууц
- Баянгол дүүргийн 17 дугаар хороонд 140 айлын орон сууцыг тус тус ашиглалтад оруулсан.

Үүнд:



2021 оны 1 дүгээр улиралд ашиглалтад орсон барилга  
Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, "Фүжи девелопмент" ХХК



34 айлын 3 давхар нийтийн зориулалттай орон сууцны Нэхмэлийн 6 дугаар байрыг  
2019 онд буулгаж 126 айлын 16 давхар барилга ашиглалтад оруулсан.

2021 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орсон барилга  
Баянгол дүүргийн 17 дугаар хороо, "Кристал инженеринг констракшн" ХХК



27 айлын 3 давхар нийтийн зориулалттай орон сууцны 27 дугаар байрыг 2020 онд  
буулгаж 126 айлын 16 давхар барилга ашиглалтад оруулсан.

### СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

2021 онд төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг нийт 3 удаа зарлаж ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцнуудыг буулган, шинээр барих төсөл хэрэгжүүлэгчээр дараах

- /БГД-03/ "Уран проект" ХХК,
- /БГД-11/ "Пример инвестмент" ХХК
- /БГД-12/ "Материал импекс" ХХК
- /БГД-14/ "Хүчит дөрвөн арслан" ХХК
- /БЗД-01/ "И Си Си ХХК"
- /БЗД-08/ "Билгүүн монгол" ХХК
- /БЗД-12/ "Хару констракшн" ХХК
- /СБД-02/ "Асиан сити ХХК"
- /СБД-03/ "Уран проект ХХК"
- /СБД-06/ "Хан хөгшин стейт" ХХК
- /БЗД-01/ "И Си Си" ХХК
- /БЗД-02/ "Ансестор" ХХК
- /БЗД-06/ "Ансестор" ХХК
- /БЗД-13/ "Вишн девелопмент" ХХК,

нийт 10 аж ахуйн нэгж шалгарч Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021 оны А/330, А/331, А/332, А/333, А/334, А/335, А/336, А/337, А/346, А/347, А/ дугаар захирамжаар тус дугаартай захирамжаар батламжилж, сууц өмчлөгч иргэн, аж ахуй нэгжтэй 2 болон 3 талт гэрээ байгуулах эрхийг олгосон.

Ирэх 4 жилд буулгах орон сууц 28 барилга

-Төсөл сонгон шалгаруулалтаар буулгах 18 барилга /Аж ахуй нэгж/

-Төсвийн хөрөнгөөр 10 барилгыг буулган дахин барилгажуулахаар төлөвлөж байна. Төслийн хүрээнд 10 байршилд 28 хуучин орон сууцны барилгыг буулган шинээр төлөвлөн барилгажуулж 632 өрхийн 2212 хүн ам эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

## ХОЁР: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ

Нийслэлийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу 2021 оны 01 дүгээр сарын 26-наас эхлэн заасан байршлуудад зах, үйлчилгээний төв, газруудад иргэд үйлчлүүлэхэд QR кодыг уншуулж хэвшсэн эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Барилга Хот байгуулалтын яамны дэд сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 150 мянган айлын орон сууцны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Баянзүрх дүүргийн гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлж буй Гангар инвест, Моннис ХХК-иудын хэрэгжүүлж буй байршилд газар дээр очиж ажиллахад танилцуулга бэлтгэн ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргаас Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо 5 шар орчмын ашиглалтын шаардлага хангахгүй болсон 1-5 дугаар байруудын дахин төлөвлөлтийн явц, хэрэгжилтийн талаар танилцуулга, мэдээллийг хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Онцгой комиссоос хүргүүлсэн шийдвэрийн дагуу 2021.02.19-ны өдрөөс 2021.02.22-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 11, 20 дугаар хороонд хэлтсийн хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн А.Дэлгэрсайхан, Д.Адьяа нар тогтоосон байршлуудад гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын хэрэгжилтэд хяналт тавин зохицуулагч хийж ажилласан.

Улсын Онцгой комиссын 5 дугаар хурлын тэмдэглэлээс гарсан үүрэг даалгавар “Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй 58 барилгын жагсаалтад байгаа байруудаас одоогийн байдлаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын тайлан мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Оргилцогцлохын Orgiltsogtslokh.e@ulaanbaatar.mn цахим хуудсаар төсөл арга хэмжээний хэрэгжилт тайлбар мэдээллийг хүргүүлэн ажилласан.

Үүнд:

Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны 53, 54 байр: Гадна инженерийн шугам сүлжээний барилга усралтын ажлыг 2019 онд нийслэлийн төсвөөс 674 сая төгрөгөөр санхүүжүүлэн төслийг хэрэгжүүлсэн.

Налайх дүүргийн 2 дугаар хороо 24, 25, 26, 27, 29, 30 байруудыг буулган барилгажуулахад 2020 онд НЗД-ын А/334 дүгээр захирамжаар нийслэлийн төсвөөс нийт 11 тэрбум төгрөг шийдвэрлэж. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Баянзүрх дүүргийн 16 хороо, Сүүний 21, 22, 27 байрыг буулган дахин барилгажуулахад гадна инженерийн дэд бүтцийн ажилд нийт 985 сая төгрөг шаардлагатай байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/505 дугаар захирамжаар Нийслэлийн боловсролын салбарт 2022 онд хэрэгжих их засварын саналыг үнэлэх, эрэмбэлэх ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд [www.brs.ulaanbaatar.mn](http://www.brs.ulaanbaatar.mn) ээр санал өгч ажилласан.

ГУРАВ: НЭГЖИЙН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

**АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ХАРИУТАЙ БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

• Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэст ирсэн албан бичиг, барилга барих хүсэлт, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулалтын баримт бичиг, тендерийн баримт бичгийн товъёог үйлдэн, нийт 179 хавтас үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.

- 733 албан бичиг ирүүлснээс 703 албан бичгийг шийдвэрлэж 30 албан бичгийг судалж байна.
- Иргэд, аж ахуй нэгж, байгууллагад 497 албан бичиг хүргүүлсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

- 273 өргөдөл гомдол ирснээс 268 өргөдөл гомдолд хариу хүргүүлж 5 өргөдөл гомдлыг судлаж байна.
- 1220 орчим иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөгчтэй биечлэн уулзаж, гэр хорооллын дахин төлөвлөлт, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах, гэр хорооллын хил хязгаарт барилга барих тухай, хууль эрхзүй норм дүрмийн талаар болон бусад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгсөн байна.

Нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрт барилга байгууламж барих зөвшөөрөл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг нэг цэг, төрийн цахим үйлчилгээгээр хүлээн авч, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах, эх зураг (эскиз) зөвшилцөх, баталгаажуулах:

Мэргэжлийн зөвлөлийн нийт 25 хурлаар нийт 315 асуудал хэлэлцүүлснээс 315 асуудал дэмжигдсэн байна.

Архитектур төлөвлөлтийн даалгавар болон загвар зураг төсөл батлагдсан байдал

Хүснэгт 1

Барилгын зориулалт	Тоон үзүүлэлт			Барилгын зориулалт	Тоон үзүүлэлт		
	АТД	Загвар зураг	Хүчин чадал		АТД	Загвар зураг	Хүчин чадал
Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны загвар төсөл	34	2	-	Эмнэлгийн барилгын өргөтгөл	-	-	-
Сайжруулсан түлшний агуулах	-	-	-	Албан контор	1	-	-
Үйлчилгээтэй орон сууц	58	26	3834	Амины сууц	5	3	3
Орон сууц	8	7	1922	Үйлчилгээтэй амины сууц	7	2	2
Үйлчилгээний барилга	11	6	-	Цэцэрлэг	7	1	150
Цэцэрлэгийн өрөгтгөл	1	2	250	Үйлчилгээтэй орон сууц /цэцэрлэг/	1	3	250
Их сургуулийн хичээлийн байр, дотуур байр	-	1	-	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор	1	1	360
Өрхийн эмнэлэг	-	-	-	Үйлдвэрийн барилга	2	3	-
Эмнэлэг	2	-	2400 м2	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн барилгажилтын төсөл	12	3	-
Дунд сургууль	-	-	-	Агуулах	-	-	-
Спорт заал	1	-	-	Дулааны станц	-	1	-
Авто гарааш	-	-	-	Сүм, хийд, шашны байгууллага	1	-	-
Авто засвар үйлчилгээний төв	-	-	-	Багш ажилчдын байр	-	-	-

Сургуулийн өргөтгөл	-	-	-	Ус дулаан дамжуулах төв	4	2	-
Сургуулийн барилга	-	2	960	Цагдаагийн кабон	-	1	-
Үйлчилгээ, конторын барилга	5	2	-	Уурын зуухны барилга	1	-	-
Үйлчилгээ, контор, зочид буудлын барилга	-	-	-	Худалдаа, үйлчилгээний барилга	-	1	-
Номын сан	1	-	-	Авто машин хийгээр цэнэглэх станц	-	-	-
Шатахуун түгээх станц	-	1	-	Цахилгаан хувиарлах байгууламж	1	-	-
Ус түгээх байр	5	4	-	Иргэдэд үйлчлэх төв	-	-	-
Гэр бүлийн хүчирхийллийн түр суурьшуулах байр	-	-	-	Аврах гал унтраах цогцолбор	-	-	-
Үүрэн холбооны станц	5	-	-	Халаалтын байгууламж	1	1	-
Хог хаягдал ангинлан ялгах үйлдвэр	1	1	-	Хорооны цогцолбор	1	1	-
Цахилгаан, ус дулаан дамжуулах дэд төвийн барилга	1	-	-	Ахмад настан, хүүхдэд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийтийн биеийн тамир амралт соёл үйлчилгээний төвийн барилга	-	1	-
Хүүхдийн зуслангийн өргөтгөл шинэчлэлтийн төсөл	1	1	-	Тохижилт	44	29	-
Хөл бөмбөгийн талбай	1	-	-	Хүзүүвчийн барилга	1	-	-

ХЕТ, хороолол, хотхоны төлөвлөлт
  ХЕТ, хороолол, хотхоны барилгатай давхацсан тоо

Байгууллагын цахим архивын баяжилт бүрдүүлэлт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн мэдээ мэдээлэл

• Хэлтсийн дотоод сүлжээнд сар, улирлын тайланг Z:\7.KHOT DAKHIN KHUGJUULEH KHELTES\7.TAILAN\2021 хавтаст, хэлтсийн төлөвлөгөөг Z:\7.KHOT DAKHIN KHUGJUULEH KHELTES\9.TULUVLUGUU\2021 хавтаст, Засгийн газрын үйл ажиллагаа, Засаг даргын захирамж, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын биелэлтийг Z:\8.KHOT DAKHIN KHUGJUULEH KHELTES\3.BIYLELT\2021 хавтаст тус тус байршуулан ажиллаж байна.

Байгууллагын /нэгжийн/ үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт /KPI/



**ХОТ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Хүснэгт 2

	<b>Үзүүлэлт</b>		2021 оны 4-р улирал
1	Архитектур төлөвлөлтийн даалгавар	Гэр хорооллын газар дахь барилга байгууламж	198/315 100%
2	Батлагдсан эх загвар зургийн тоо		168/146 86%
3	Архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийг шийдвэрлэх		14/14 100%
4	Ашиглалтанд орсон нийтийн болон амины орон сууц	Гэр хорооллын дахин төлөвлөх төслийн хүрээнд баригдсан орон сууцны тоо, хүчин чадал	7/695
5		Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулгаж баригдсан орон сууцны тоо, хүчин чадал	2/266

**ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль"-ийг дагалдах дүрэм, журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 167, 2017 оны 145 дугаар тушаалаар тус тус шинэчлэн байгуулагдсан. Ажлын хэсгээс хуулийг дагалдан гарах дараах журмыг боловсруулан баталсан. Үүнд:

- Барилга хот байгуулалтын Сайдын 2016 оны 122 дугаар тушаалаар “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”
- Барилга хот байгуулалтын Сайдын 2016 оны 125 дугаар тушаалаар “Хот, суурин газрын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”
- Барилга хот байгуулалтын Сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”
- ЗГ-ын 2018 оны 222 дугаар тогтоолоор “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”
- ЗГ-ын 2018 оны 341 дүгээр тогтоолоор “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа дахь газраар хувь нийлүүлэх журам”
- Дээрх батлагдсан журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын өөрчлөлтөд боловсруулан ажиллаж байна. Цаашдаа газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран журамд оруулах өөрчлөлтийг эцэслэн боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд санал хүргүүлсэн.
- “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэргэжлийн зүгээс Хуулийн хэлтэст санал өгч ажилласан.
- “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-д ажил, мэргэжлийн зүгээс санал өгсөн.
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эдэлбэр газар, түүний хэмжээ, ашиглалтын журмын төслийг боловсруулж хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

**ДӨРӨВ: НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Нэгжийн баримт бичгийн цахим архивыг бүрдүүлэх, шинэчлэх хүрээнд хийгдсэн ажил:

Мэргэжлийн зөвлөлийн хурлаар дэмжигдсэн 96 архитектур төлөвлөлтийн даалгаврыг байгууллагын e-registration программд бүртгэж, хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэн ажиллаж байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг барилгыг буулган шинээр барих ажлын талаар нийт 6 телевизэд /“Сүлд телевиз”. TV-8, TV25, TV-9, News.mn, Eagle-TV, МҮОНРТ-ийн оцлох зочны цагт/ ярилцлага өгч мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллав.

## АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэлтсийн албан хаагчид хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг дурдсан хугацаанд бүрэн гаргаж, Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн.

## ҮНЭЛГЭЭ ХОРОО, АЖЛЫН ХЭСГҮҮДЭД ОРЖ АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Барилга Хот байгуулалтын яамны ажлын хэсэг

- 2021.01.20-ны өдрийн 10 тушаалаар батлагдсан Аймаг, нийслэл, сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын суурьшлын бүсэд амьдардаг өрхүүдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц шинээр барих эсхүл баригдсан амины орон сууцыг өргөтгөх, шинэчлэх, засварлах, тоноглоход шаардлагатай урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох хүрээнд тус амины орон сууцанд тавигдах шаардлагыг тодорхойлох, зээлийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх санал, зээл олгох үйл ажиллагааны журам төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт хэлтсийн дарга ажиллаж байна. Нийт 4 удаагийн захим хуралд сууж журмын төсөлд дараах санал боловсруулж хүргүүлсэн
- 2021.02.16-ны өдрийн 38 тушаалаар батлагдсан Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан батлагдсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэгт хэлтсийн дарга ажиллаж байна.  
Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг
- 2020.11.24-ний өдрийн А/1255 дугаар захирамжаар ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төслийг эрчимжүүлэх, асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсэгт хэлтсийн хамт олон ажиллаж байна.
- 2020.11.27-ны өдрийн А/260 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Орон сууцны 7 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2011, 2012 онуудад нийслэлийн төсвийн хөрөнгөөр газар нь чөлөөлөгдсөн 326 нэгж талбар тус бүр дээр тооллого явуулж, нөхцөл байдлыг тогтоох, газар ашиглалт, цаашид авах арга шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт хэлтсийн дарга ажиллаж байна.
- 2020.11.30-ны өдрийн А/1262 дугаар захирамжаар Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний “Нэг төвт хотоос олон төвт хот болох” зорилтын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй дэд төв, олон нийтийн төвүүдийг бий болгох ажлыг эрчимжүүлэх, удирдан зохион байгуулах үүрэг бүхий байнгын ажилгаатай ажлын хэсэгт хэлтсийн дарга ажиллаж байна.
- 2021.02.08-ны өдрийн А/69 дугаар захирамжаар Гар хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хэрэгжилтэд хяналт тавих, төслийн хэрэгжилттэй холбоотой гомдол, саналыг хэлэлцэх, нөхөх олговрын хэмжээг тогтоох зорилгоор үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт хэлтсийн дарга ажиллаж байна.  
Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албны даргын тушаал
- 2021.03.11-ний өдрийн А/49 дүгээр тушаалаар барилга, замын ажлыг гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай ажлын хэсгийг мэдээлэлээр хангаж ажиллаж байна.  
Дүүргийн засаг даргын захирамж

- 2021.03.16-ны өдрийн А/139 дүгээр захирамжаар Хан-Уул дүүргийн хэмжээнд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад нэгдсэн хяналт, шалгалт хийх ажлын хэсэгт хэлтсийн хот байгуулалт хариуцсан мэргэлжилтэн Э.Мөнх-Эрдэнэ ажиллаж байна.
- 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан хуулийн сургалтын хөтөлбөр”-т цахим хэлбэрээр хэлтсийн нийт албан хаагч хамрагдсан.
- 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Газрын тухай хуулийн шинэчлэсэн найруулгын хэлэлцүүлэгт оролцож санал өгч ажилласан.
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 02-07-383/1419 дүгээр шийдвэрийг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдож, ашиглахыг хориглосон Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн ажилчдын байр, Улсын их дэлгүүрийн ажилчдын байр, Номын худалдааны ажилчдын байруудыг буулган дахин барилгажуулах тухай захирамжийн төсөл, танилцуулга материал бэлтгэн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- Үндэсний хөгжлийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 01/455 дугаар албан бичгийн хүрээнд Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 58 барилгыг буулган, шинээр барих төслийн мэдээллийг Монгол, Англи хэлээр бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Нийт 37 хайрцаг материалын цахим архив хийж гүйцэтгэн Захиргаа санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгсөн.
- Дугуй цагаан, Туул голын тохижилтын ажлын ажил гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулж хянат батлуулсан.

## ТАВ: БУСАД МЭДЭЭЛЭЛ

### ЦАГ ҮЕИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХИЙСЭН АЖИЛ:

- Дэм дэмэндээ аянд нэгдэн хэлтсийн хэмжээнд 50 000 төг-ийн хандивыг зорилтот өрхөд хандивласан.
- “Хүүхдийн төлөө фонд”-д нэгдэн 1 өдрийн цалингаа хандивласан.
- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хот дахин хөгжүүлэх ажлын хүрээнд хийгдэх ажлын төсөлд санал өгч ажилласан.
- “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-д ажил, мэргэжлийн зүгээс санал өгсөн.
- <http://mongol-bichig.1212.mn/> програм хангамжаар Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистикийн газраас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа-2021-д хамрагдсан.
- Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт ажиллан, үйлчилгээтэй орон сууцны барилга барихаар газар шорооны ажил эхэлсэн “Марта Грийн” ХХК-ийн зөвшөөрлийг одоогийн нөхцөл байдалтай уялдуулан холбогдох хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэх үүрэг даалгаврын дагуу албан уулзалт зохион байгуулж Хот байгуулалт хөгжлийн газрын цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.
- Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар Сүхбаатар дүүргийн 3, 4, 16 дугаар сургууль, Чингэлтэй дүүргийн 39, 24 дүгээр сургууль, онцгой комиссын шуурхай штаб, дээр ажиллаж цаг үеийн мэдээллийг авч тайлан мэдээг 14, 18 цагуудад Захигаа санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
- Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын авто зам, тохижилт, ногоон байгууламжийг ашиглах хамгаалах журмын дагуу орц гарц гаргах хүсэлт гаргасан аж ахуй, нэгж байгууллагуудын хуралд зүүм аппликейшн ашиглан оролцож батлагдсан эх загвар зурагт тайлбар мэдээлэл өгч ажилласан.

- Хот байгуулалт хөгжлийн газрын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор I-UP цонхыг ашиглаж эхэлсэнтэй холбоотой ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын хэрэгжилт болон үйл явцын талаар видео танилцуулга бэлтгэн байгууллагын <http://uda.ub.gov.mn/> цахим хуудсанд байршуулж ажилласан.
- Монгол Улсын их хурлын гишүүн Б.Саранчимэг, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын удирдлагууд болон төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл Хайрцагны 24 дүгээр байрны төслийн үйл явцтай газар дээр нь танилцан иргэд, оршин суугчдын саналыг сонсож цаашид ажлыг эрчимжүүлэх шаардлагатай тухай үүрэг даалгавар өгч ажилласан.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нийслэлийн төсөв бүрдүүлэгч болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим байгууллагын албан хаагчидтай хийх уулзалтад өөрийн байгууллагын танилцуулга бэлдэж ажилласан.
- 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Барилга, Хот Байгуулалтын Яаман дээр Urban.gov.mn сайтын хөгжүүлэлт болох Төрийн үйлчилгээг цахим болгох ажлын хэсгийн хуралд оролцсон.
- 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Баянзүрх дүүргийн 13-р хорооны иргэдээс ирсэн гомдлын дагуу “Оргил саран” ХХК-ны 5 давхар үйлчилгээний барилгын ажлын явцтай газар дээр нь очиж танилцан Барилгын түр хашаа сайжруулах тухай Улаанбаатар хотын ерөнхий архитекторын шаардах хуудас хүргүүлэн ажилласан.
- 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатар дүүргийн 9-р хороо орон сууцны 7-р хороолол Нийслэлийн төсвийн хөрөнгөөр чөлөөлсөн 326 нэгж талбарт судалгаа хийж танилцуулга бэлдэн Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Н.Наранбаатарт танилцуулж ажилласан.
- 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр дээрх ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9-р хорооны байршил ногоон нуур орчимд Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд холбогдох албаны хүмүүстэй байршил дээр нь очиж ажилласан.
- 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт хуучин Нэхмэлийн шар байруудын дахин төлөвлөлтийн хүрээнд баригдсан орон сууцны барилгын дунд хийгдэж байгаа тохижилтын ажлын явцын талаар Нийслэлийн мэдээ цахим хуудсанд ярилцлага өгсөн.
- 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр дээрх ажлын хүрээнд UBS телевиз “Ажилсаг Улаанбаатар” нэвтрүүлэгт оролцсон.
- 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр “Тулах цэг” ХХК-ны орон сууцны барилга барих хүсэлтийн дагуу газар дээр нь очиж судалгаа хийж ажилласан.
- 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр Баганат өргөө ХХК-ны орц гарц замын асуудлын талаар байршил дээр нь ажилласан.
- 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо иргэн Төмөрхуяг, Батсуурь, Гантулга нарын орон сууцны барилга барих хүсэлтийн дагуу газар дээр нь очиж танилцсан.
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэх, хамгаалалтын бүсийн хил заагт өөрчлөлт оруулах талаар санал өгсөн.
- Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай хуулийн төсөлд санал өгж ажилласан.
- Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэр болох нийт 11,3 га газрын гудамж талбайн тохилтын ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж батлуулсан.
- Газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/59 дүгээр тушаалаар сэлгэн томилогдсон албан хаагчид ажлаа хүлээлцсэн ба зарим чиг үүрэг Хот төлөвлөлтийн хэлтэсрүү шилжсэнтэй холбоотой барилга барих хүсэлт, загвар зураг батлуулах хүсэлт, эргэлтийн цэг өөрчлүүлэх нийт 64 материалыг хүлээлгэн өгсөн.

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860, А/1201 дугаар захирамжийн дагуу боловсруулж буй “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад Захиалагчийн хяналт тавих чиг үүргийн хүрээнд төлөвлөлтийн баримт бичгийн “ДУНДЫН ТАЙЛАН”-г 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Баасан гаригт 07 цагаас Хангарди ордны 14 давхрын хурлын Их танхимд “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ээс нийт албан хаагчдад танилцуулах нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон.
- Үндэсний хөгжлийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 01/455 дугаар албан бичгийн хүрээнд Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 58 барилгыг буулган, шинээр барих төслийн мэдээллийг Монгол, Англи хэлээр бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Нийт 37 хайрцаг материалын цахим архив хийж гүйцэтгэн Захиргаа санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгсөн.
- 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн 10-р хороо 7-н барилгыг дахин төлөвлөн барилгажуулах талаар танилцуулга бэлтгэж Сүхбаатар дүүргээс сонгогдсон Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүдтэй хамтарсан уулзалт зохион байгуулсан.
- Дугуй цагаан, Туул голын тохижилтын ажлын ажил гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулж байна.
- 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгал, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн загвар батлах комиссын хурлыг зохион байгуулахаар ажиллаж байна.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт судалгааны хэлтсээс зохион байгуулагдсан албан хэрэг хөтлөлт /журам, ер. Edoc. Өргөдөл гомдлын систем/, албан бичгийн найруулгын сургалтад zoom аппликейшн ашиглан хэлтсийн 10 албан хаагч хамрагдаж, сертификат авсан.
- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст Бодлогын инноваци-Вебинар №4 хэсэгт тавигдсан “Төрийн байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад удирдлага ба нийтийн албан тушаалтны үүрэг” сэдэвт цахим хичээлтэй танилцаж, мэдээлэл авч ажилласан.
- "Төрийн албан хаагчийн манлайлал ба гүйцэтгэлийн менежмент" сэдэвт сургалтад 2021.10.01-ний өдөр,
- "Албан хаагчийн зөөлөн ур чадвар хөгжүүлэх туршлага" сэдэвт сургалт 2021.10.28-ны өдөр,
- "Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт "Алсын хараа-2050" сэдэвт сургалтад 2021.10.11-22 өдөр,
- 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим системийг ашиглах нь” сэдэвт сургалтад цахим хэлбэрээр тус тус хамрагдсан.
- 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Хот байгуулалтын мэдээллийн хэлтэс, Залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан “Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн хэрэглээ” сэдэвт анхан шатны сургалтад танхимын хэлбэрээр хамрагдсан.

## ТАЙЛАН МЭДЭЭ

- Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Ерөнхий сайдын Албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Онцгой комиссын хуралдааны тэмдэглэл зэрэг холбогдох хууль тогтоомжийн биелэлт гаргасан.



- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хавсралт баримт бичиг болох “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т нэмэлт өөрчлөлт оруулах саналыг судалж тайлбар өгсөн.
- Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан санамж бичгийн биелэлт, тайланг бэлтгэн ажилласан.
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг тус тус тайлагнаж ажилласан.

ХЯНАСАН:

ХОТ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГА

М.МЭНДСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.СОДБИЛЭГ

2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр.